



Р.УУГАНБАЯР

ХСИС-ийн Шүүхийн
шийдвэр гүйцэтгэлийн
сургуулийн Эрүүгийн ял
эдлүүлэх эрх зүйн
тэнхимийн багш, ахмад

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ЯЛТНААС ҮЙЛДДЭГ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ОНЦЛОГ

Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хорих байгууллагад хоригдож байгаа хоригдогч, ялтны дотроос гэмт хэрэг үйлдэх, нийгэм ард иргэдийг гэмт халдлагад өртөхөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага юм. Энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэх, хорих байгууллагын аюулгүй байдал цаашлаад нийгмийн аюулгүй байдлыг хамгаалахад гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажиллагааг улам эрчимжүүлэх шаардлага тулгарч байна.

Хорих ял эдлэж байгаа ялтны дийлэх хувийг хүнд, онц хүнд гэмт хэрэгт ял шийтгүүлсэн олон жилийн ялтай хоригдлууд эзлэх болсон, мөн албан тушаалын болон зохион байгууллалттай гэмт хэрэг үйлдсэн, нэр нөлөө бүхий, мөнгө хөрөнгөтөй ялтнуудын тоо нэмэгдэж байгаатай холбогдон хорих байгууллагад гэмт хэргийн бүлэглэлүүд бий болох, улмаар зохион байгуулалтгад орж хорих байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах, нийтийг хамарсан өлсгөлөн суулт зарлах, бусдыг барьцаанд авах, үймээн самуун дэгдээх зэрэг ноцтой гэмт хэрэг, зөрчлүүд гарах магадлал өндөр байгаа нь гэмт хэрэг, эрх зүйн

зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг оновчтойгоор явуулах шаардлагыг бий болгож байна.

Хорих ял эдлэгсдийн криминологи шинжийн гол элемент болсон бие хүний судалгаанд онцгой анхаарал хандуулах нь тэдний зүгээс үйлдэх гэмт явдлын шалтгаан нөхцлийг тогтоох, үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийг цаг хугацаанд нь илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулах урьдчилсан нөхцөл болдог.

Хорих ангид ялтны зүгээс үйлддэг түгээмэл гэмт хэрэг, зөрчилд анализ хийн үзвэл үүнд:

- Шүүх, цагдан хорих, хорих ангиас оргох /Эрүүгийн хуулийн 261-р зүйл/, Хорих ял эдлэхээс зайлсхийх /мөн хуулийн 262-р зүйл/ гэсэн гэмт хэргүүд юуны өмнө хамаарах ба тэд “пенитенциар гэмт явдал”-ын бүтцэд голлох байр суурь эзэлдэг.

- Дараагийн дугаарт Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид тусгагдсан тухайлбал, бусдыг алах, бусдын бие махбодид хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл учруулах, танхайрах, бусдын эд зүйлийг булаах, дээрэмдэх, хулгайлах, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах зэрэг хүч хэрэглэсэн гэмт хэргүүд давамгайлдаг.

- Согтууруулах ундаа, хар тамхи, мансууруулах бодисыг хорих ангид оруулах, ялтнуудад дамжуулах болон хориглосон бусад эд зүйлийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг, эрх зүйн зөрчлүүд. Согтууруулах ундаа, мансууруулах бодисыг хорих ангийн бичил орчинд хэрэглэх нь түүний аюул занал, хор үр дагаврыг улам нэмэгдүүлдэгийг онцгойлон тэмдэглэх хэрэгтэй. Олон улсын практикаас үзвэл гадаадын зарим орны хорих ангиуд, ялтнууд

хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлтийн гол объект, субъект болсон тухай судлаачид тэмдэглэж байна. Хорих ангид оруулах, ялтнуудад дамжуулахыг хориглосон аливаа зүйлийн хууль бус эргэлт нь хорих ангийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, эрүүгийн нөхцөл байдлыг хүндрүүлэх, цаашилбал гэмт хэрэг гарах эх үүсвэр болдог тул тэдгээрийг анхаарлын гадна үлдээж хэрхэвч болохгүй.

• Хорих анги, гянданд ялтнуудын гаргасан гэмт хэрэг нь эрүүгийн эрх зүйн үүднээс давтан гэмт хэрэг үйлдсэнд тооцогдон зүйлчлэгдэж оногдуулах ял нь ч нэмэгддэг онцлогтой. Мөн гэмт хэргийн хохриогч нь ихэвчлэн тэдэнтэй ял эдэлж буй хоригдол /зарим тохиолдолд хорих ангийн албан хаагч, ажилтан, ялтны ар гэрийнхэн байх боломжтой/ байдаг нь энэ гэмт хэргийн дараагийн нэг онцлог мөн.

• Хорих ял эдлэгсэдийн хувьд тэд ихэвчлэн согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гэмт хэргээ үйлдсэн байдаг, мөн тэдний ойрын найз нөхөд нь ч согтууруулах ундааны байнгын хэрэглэгч байдаг. Иймээс хоригдлууд, ялангуяа олон жилийн ялтай этгээдүүд согтууруулах ундаа хэрэглэхийг санал болговол ихэнхи тохиолдолд татгалздаггүй, түүнчлэн хэтрүүлэн хэрэглэх зуршилтай байдаг. Чанга, онцгой дэглэмд хорих ял эдлэгсэдийн дийлэнхи хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байгаагүй хүмүүс байдаг. Харин ажил хөдөлмөр эрхэлж байсан бол ихэнх тохиолдолд ажилласан хугацаа нь бага, хөдөлмөрийн хамт олонтойгоо байнгын холбоо тогтоож чадаагүй байдаг.

Хорих ангийн харуул хамгаалалтын нөхцөл байдлыг судалж үзэхэд хорих ангийн аюулгүй байдалд хохирол учруулах, хэвийн үйл ажиллагааг алдагдуулах талаарх

ялтнуудын зүгээс явуулж буй сөрөг үйл ажилгааг авч үзвэл:

-тус хорих ангийн газар зүйн байршил, албан хаагчдын тоо, хамгаалалтын бүсийн талаар судлах

-хамгаалалтын тоног төхөөрөмжийг гэмтээх, ажиллагаагүй болгох талаар судлах

-ялтнууд нь өөрийн хань хамсаатантай холбоо харилцаа тогтоохыг оролдох

-хорих байгууллагын ажилтан, албан хаагчдыг өөрийн үйл ажиллагаандаа ашиглахаар сонирхох, энэ талаар идвэхтэй байдлаар ажиллах

-хорих байгууллагын хэвийн үйл ажиллагаанд гаднаас халдах, үйл ажиллагааг алдагдуулахыг оролдох /хэвлэл мэдээллийн хэргэсэл болон эрх чөлөөтөй байгаа хань хамсаатнаар дамжуулан/

-хамт ял эдэлж буй ялтануудаас өөрийн бүлэглэл бий болгох, шаардлагтай тохиолдолд тэдгээрийг ашиглах, өөрийн гэмт ажиллагаанд татан оролцуулах, айлган сүрдүүлэх, дарамтлах, өдөөн турхирах, зорилготойгоор гал хам гэсэн халхавчтайгаар эрхшээлдээ байлгах.

-ял эдлэхээс зайлсхийх зорилготойгоор хорих ангиас оргон зайлах:

-ял эдлэхээс зайлсхийх зорилготойгоор амиа хорлох:

-урьд үйлдсэн гэмт хэрийг нуун дарагдуулах, худал ташаа зүйл ярих, төөрөгдүүлэх:

- өөрт ашигтай шийдвэр гаргуулах зорилгоор бие эрхтэндээ гэмтэл, учруулах, гэмтэл учруулахаар заналхийх:

-хорих ангид мөрдөгдөх хууль, журам зөрчсөн орчин нөхцөл бий болгохыг санаархах:

-нийгэмд өрнөж байгаа зарим хөдөлгөөн, тэмцлийг хууль хэлбэрээр

дэмжих, дэмжихийг уриалах, нийтийг хамарсан эмх замбраагүй байдал бий болгох,

-хорих ангийн үйл ажиллагаанд ноцтойгоор нөлөөлөх сөрөг цуурхал дэгдээх, мэдээлэл тараах:

-бусдыг өдөөн турхирах

-ял эдэлж байгаа ялтанууд нь алба хаагчдыг ашиглан өөрсдийн гэмт үйлдэл болон гадна байгаа гэмт хэргийн оролцогч, бусад этгээдүүдтэй холбоо тогтоох, хорих ангиас гэмт хэрэг удирдан зохион байгуулах, гэмт хэргийн хохирогч нарыг дарамтлах, гэмт хэргийн ул мөрийг баллах, хууль бусаар олж авсан эд хөрөнгийг нуух гэх мэт хэлбэрээр явуулж байдаг.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад ялтан бие хүнийг судлах нь томоохон байр, суурь эзэлдэг, чухал зангилаа асуудал билээ. Ялтан бие хүнийг төлөвшсөн онцлогийг судлахгүйгээр гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг илрүүлж, арилгах, хүнийг хүмүүжүүлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм. Гэмт хэрэгтэн бие хүнийг судлах судалгааны зорилго бол амьдралын тодорхой нөхцөлд тухайн хүний зан төрхийн онцлогт тохирсон шийдвэр гаргаж, түүнд эерэг байдлаар нөлөөлөх, гэмт зан төлөв үүсэх буюу төлөвшин тогтох, бие хүн түүний орчны харилцан үйлчлэлийн механизмыг олж илрүүлэх, улмаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөв чиглэлийг тодорхойлоход оршино.

Тодорхой дэглэм бүхий хорих ангид ял эдлэгсдийн онцлог шинжүүдийг нээн гаргахын тулд криминологийн шинжлэх ухааны арга зүйд тулгуурлах нь хамгийн оновчтой шийдэл мөн. Нөгөө талаас Хорих байгууллага, тэнд ял эдлэгсэд нь криминологийн шинжлэх ухааны гэмт хэрэгтэн бие хүний талаархи судалгааны

томоохон объект, бааз суурь болдогтой холбоотой.

Шүүхээс гэмт хэрэгтэн бие хүний хорих ял эдлэх байгууллагын төрөл, дэглэмийг тогтоохдоо тэдгээрийн физиологийн болон Эрүүгийн эрх зүйн шинжүүдийн онцлогийг харгалздаг. Өөрөөр хэлбэл Шүүхээс хорих ял эдлэгсдийг тодорхой дэглэм бүхий хорих ангид ял эдлүүлэхээр шийтгэж байгаа явдал нь гэмт хэрэгтэн бие хүнийг физиологийн болон эрүүгийн эрх зүйн тодорхой шинж, шалгуураар бүлэглэн ангилж буй явдал мөн. Тиймээс ерөнхийгөөс тусгайд шилжих диалектик категорийн дагуу гэмт хэрэгтэн бие хүн, хорих ял эдэлж буй гэмт хэрэгтэн бие хүн, тодорхой дэглэм бүхий хорих ангид ял эдэлж буй гэмт хэрэгтэн бие хүн гэж ангилж болох талтай. Хорих ял эдлэгсэд нь ял эдэлж буй дэглэмийн ялгаатай уялдан, эрүүгийн болон бусад шинжээрээ хоорондоо ялгаа бүхий онцлогтой бөгөөд тэдгээрийг нээн гаргах нь практик болоод онолын ихээхэн ач холбогдолтой гэж үзсэн болно.

Монгол Улс нийгмийн болон эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжиж буй сүүлийн жилүүдэд гэмт хэргийн тоон үзүүлэлт өсөхийн хамт гэмт үйлдлийн арга нарийсч илүү хор аюултай болж өөрчлөгдөж байгаа ба зохион байгуулалттай, нийгэм эдийн засаг, улс төр, бизнесийн салбар түүнчлэн эрүүгийн гэмт хэрэгтнүүдийг хамарсан шинэ өнгө аяс бүхий бүлэглэлүүд үүсч эрүүгийн гэмт хэргийн нөхцөл байдал хүндэрсээр байна. Өнөөгийн нийгмийн хөгжил, өөрчлөлттэй уялдан зарим үйлдэгдэж байгаа гэмт үйлдлийн арга хэт харгис, хэрцгий шинж агуулахын зэрэгцээ сэтгэцийн өөрчлөлттэй, мансуурах элдэв гаж донтой хүмүүс гэмт хэрэг үйлдэх нь ихэсч байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Түүнчлэн хоригдогсод нь хорих анги, баривчлах цагдан хорих байранд бусдын амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж байгаа, мөн хорих ангиас харуул хамгаалалтын сул байдал эсхүл тухайн анги, албаны үйл ажиллагааны онцлог байдлыг ашиглан хамгаалалтын инженер техникийн хэрэгсэлийг эвдэх, зориулалтын саад, төхөөрөмжийг давж туулах замаар ганцаар болон бүлэглэн оргох гэмт хэрэг үйлдэгдсээр байна. Энэ нь хорих ангийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрхэн үр дүнтэй зохион байгуулах зүй тогтлыг онолын үүднээс шат дараатай судлан, практик ач холбогдлыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагыг бий болгож байна

**Б.МӨНХБААТАР**

ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн багш, ахлах дэслэгч

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ДАХЬ УГСААТНЫ СЭТГЭЛ ЗҮЙН ХАРИЛЦАН ХАМААРАЛ

Монгол хэлний тайлбар толинд:

Угсаатан (ᠤᠭᠰᠠᠭᠠᠲᠠᠨ) — нэгэн төрлийн хэлтэй ард түмэн. Үндэстнээс өргөн арьстнаас явцуу хэмжээний ард түмний хуваарь.

XVIII зуунд Францын соён гэгээрүүлэгчид “ард түмний оюун сэтгэл” гэдэг ухагдахууныг юуны өмнө газар зүйн хүчин зүйлс, цаг уур, түүнчлэн шашин, зан заншил, өнгөрсөн үеийн түүх, үлгэр домог зэрэг ард түмний өвөрмөц онцлогийг тодорхойлж чадна гэж тайлбарласан байдаг. Аливаа үндэстний сэтгэл зүйн байдал нь түрүүчийн үе удмаас өвлөгдөж ирсэн амьдралын ёс заншил, уламжлалын үр дүнд бүрэлдэн тогтсон сэтгэхүйн хэв маяг зан үйлд илэрдэг байна. Энэ нь түүхэн хөгжлийн бүрэлдэхүүн бөгөөд нэг үе удмаас нөгөө үе удамд тайван алгуур тогтвортойгоор дамжин бий болдог гэж үздэг.

Үндэсний шинж байдал гэдэг ухагдахууныг эхэн үед ард түмний аж амьдралыг илэрхийлэх зорилготой тодотгодог байсан хэдий ч өнөөгийн нийгэмд үндэстний шинж байдлыг судлахдаа тэдний ааш араншин, хүний